



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Бизнесийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Эдийн засаг

Индекс: D031101

Шинжээчийн баг:

Ахлагч: Ц.Даваадорж

Гишүүд: Х.Цэвэлмаа

Л.Отгонжаргал

Он сар өдөр: 2019-05-30

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Шалгуур 6: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ACBSP	Accreditation Council for Business Schools and Programs
CLO	Course Learning Outcome
OGSM	Objectives, Goals, Strategies and Measures
PEST	P-Politic, E-Economy, S-Social, T-Technology
PLO	Program Learning Outcome
SWOT	Strengths, Weaknesses, Opportunities, Threats
ААН	Аж ахуйн нэгж
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
БС	Бизнесийн сургууль
ЕШ	Ерөнхий шалгалт
МУИС	Монгол улсын их сургууль
ОХЭДТ	Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв
СЭЗ	Санхүү, эдийн засаг
УЗ	Удирдах зөвлөл
ХААИС	Хөдөө, аж ахуйн их сургууль
ХИС	Хүмүүнлэгийн ухааны их сургууль
ШУС	Шинжлэх ухааны сургууль
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЭЗБС	Эдийн засаг, бизнесийн сургууль
ЭШБХ	Эрдэм шинжилгээний бага хурал

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Бизнесийн сургууль University of the Humanity, Business school	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Эдийн засаг Economics	
Индекс	D031101	
Шинжээчид	<ul style="list-style-type: none"> Ц.Даваадорж-Монгол-Японы төвийн захирал Х.Цэвэлмаа-МУИС, ШУС-ийн Эдийн засгийн тэнхимийн профессор Л.Отгонжаргал-ХААИС, ЭЗБС-ийн маркетингийн тэнхимийн эрхлэгч 	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Оюунчимэг-Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө, хэрэгжилт	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2019-04-24	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон. №104
	2019-04-24	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2019-05-10	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2019-05-22-23	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2019-05-30	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	2019-05-31	Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.
	2019-06-05	Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.
Шалгуур шаардлага /журам/	<ol style="list-style-type: none"> Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрмийн 8.4.5, Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмын 2.2 БМИҮЗ-ийн УЗ-ийн 2018-06-26-ны өдрийн 08 тоот тогтоолын гуравдугаар хавсралт “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага” 	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж: Санхүү, эдийн засгийн тэнхим

- Байгуулагдсан он: 2007, 2009
- Хэрэгжүүлж буй хөтөлбөр: Эдийн засаг (Бакалавр, магистр), Нягтлан бодох бүртгэл (Бакалавр), Санхүү (Бакалавр)

Эдийн засаг хөтөлбөрийн зорилго: *Улсын болон хувийн байгууллагуудад тулгамдаж буй эдийн засгийн асуудлыг ялган таньж, салбар болон улсын хэмжээний мэдээлэл боловсруулах, дүгнэлт гаргах, прогноз, төлөвлөлт хийх гэх мэт тухайн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай гадаад хэл, эдийн засгийн онолын болон бизнесийн удирдлагын мэдлэгтэй, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр ашгийг тооцох, эрсдэлийг тодорхойлох, бууруулах арга замыг тогтоох, зах зээлийн шинжилгээ хийх, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудад судлаачаар ажиллах чадвартай, өөрийгөө тасралтгүй хөгжүүлдэг, мэргэжлийн ёс зүйтэй мэргэжилтэн бэлтгэх*

Эдийн засаг хөтөлбөрөөр тасралтгүй 10 удаагийн элсэлт авч, 7 удаагийн төгсөлтөөр нийт 150 гаруй оюутан амжилттай төгссөн байна.

2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар Эдийн засаг хөтөлбөрт 188 оюутан суралцаж байгаа ба хөтөлбөрийг үндсэн 13 багш, 4 цагийн багш хэрэгжүүлж байна.

Тухайн хичээлийн жил	Суралцагчдын тоо
1-р курс	74
2-р курс	53
3-р курс	44
4-р курс	17

Энэ хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд гарсан өөрчлөлтүүдийг нэгтгэн үзвэл:

Сургалтын түвшин	2014 он	2016 он	2018 он	2019 он
I. Ерөнхий суурь хичээл	23%	23%	25%	30%
II. Мэргэжлийн суурь хичээл	20%	20%	20%	25%
III. Мэргэжлийн хичээл	58%	57%	55%	45%

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэх ажлын явцын талаар:

ХИС-ийн захирлын 2018-10-29 өдрийн А/333 тоот тушаалаар өөрийн үнэлгээний багийг байгуулсан.

2019.01.09 БМИҮЗ-ийн мэргэжилтэн Б.Мядагмаа, Б.Оюунчимэг нар "Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан бэлдэх арга зүйн зөвлөмж" сургалтыг явуулсан.

2019-03-22 өдөр БМИҮЗ-тэй гэрээ байгуулсан.

2019-04-19 өдөр тайланг хүлээлгэн өгсөн.

2019-05-22-23 өдрүүдэд шинжээчийн багийг хүлээн авсан.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга /PEST, STEEP гэх мэт/

- Гадаад, дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Уг хөтөлбөр нь Монголын бусад их, дээд сургууль болон гадаадын зарим их сургуульд хэрэгжүүлж байгаа эдийн засгийн хөтөлбөрүүдтэй жишихүйц түвшинд явагдаж байна;
- Сонирхогч талуудын эрэлт, хэрэгцээг судалж, хөтөлбөрт тусгах ажлыг тууштай хэрэгжүүлж байгаа;
- PEST судалгааг хийж, хөтөлбөрөө сайжруулах алхамыг хэрэгжүүлж буй;
- Гадаад хэлтэй мэргэжилтний эрэлт ихсэж байгаа;
- Хөтөлбөрийн суурь хөрвөх чадвар өндөр байх нийгмийн эрэлт ихсэж байгаа;

- Хөтөлбөрийн шинэчлэлт сүүлийн 2-3 жилд эрчимжиж байгаа;
- Монгол Улсад шаардлагатай буюу эрэлттэй байгаа мэргэжилтнийг нийлүүлэхэд хувь нэмэр оруулж байгаа;
- Бизнесийн шинжээчийн эрэлт ихсэж байгаа тухай ажил олгогчид саналаа илэрхийлсэн.

Анхаарах асуудал:

- Эдийн засгийн хөтөлбөр боловч бусдаас ялгарах онцлог нь чухам юу болох тал дээр талууд нэгдсэн ойлголттой болох; тайлан дээр өгөгдлийн шинжээчээр мэргэших чиглэлтэй мэт бичсэн байхад ярилцлагын явцаас харахад бизнес шинжээч гэж зарим нь үзэж байгаа, өөр нэг хэсэг нь олон улсын эдийн засагчаар мэргэшсэн мэт тайлбарласан.
- Дотоод, гадаадын бусад их сургуулийн эдийн засгийн хөтөлбөртэй харьцуулсан судалгааг улам нарийвчлан тодотгох, ойлгомжтой байдлаар нэгтгэн харуулах;
- OGSM шинжилгээг илүү аналитик болгох, холбогдох тоо мэдээллийг цуглуулах, тэдгээрт тулгуурлан хамаарлын дүн шинжилгээ хийж, үр дүнг нь хөтөлбөрийн төлөвлөлтийн шийдвэр гаргалтад ашиглах, стратегийн дараагийн алхмыг бэхжүүлэхэд хэрэглэх;
- PEST шинжилгээнээс харахад эдийн засгийн хөтөлбөрт шууд нөлөө багатай, харин шууд бус болон дам нөлөө үзүүлэх талтай байгааг анхаарах;
- Хөтөлбөрт хамааруулж буй хичээлүүд нь бусад харьцуулалт хийсэн их сургуулиудын хөтөлбөрт байгаа хичээлүүдээс ялгарах онцлог харагдахгүй байгаад анхаарал хандуулж, өөрийн хөтөлбөрийн онцлог, ялгааг илүү тодотгох, түүгээрээ хөтөлбөрийн нэр хүндийг бэхжүүлэхэд анхаарах;

Зөвлөмж:

- ХИС, БС-ийн удирдлага, СЭЗ-ийн тэнхимийн багш нар болон оролцогч бусад талуудын ойлголтыг нэгдмэл болгох талаар анхаарах;
- Аль талаар мэргэшиж байгаагаас хамааран хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлох судалгааны асуулт, нэгтгэл, үр дүн хамаарахыг анхаарах;
- Дотоод, гадаадын бусад их сургуулийн эдийн засгийн хөтөлбөртэй харьцуулсан судалгааг улам нарийвчлан тодотгох, ойлгомжтой байдлаар нэгтгэн харуулбал уг хөтөлбөрийн ялгагдах онцлог, давуу тал илүү сайн харагдах талтай;
- Хөтөлбөрийн харьцуулалт хийж буй гадаадын гурван их сургуулийн эрэмбийг цаашид анхаарах;

- Гадаад хэлний хэрэглээ ихсэж байгаатай холбоотойгоор эдийн засгийн хөтөлбөр нь хятад, орос хэл, бусад хэлийг хослуулан хэрэглэх боломжтой байгааг гүнзгийрүүлэн судлах;
- Код бичих, тоон боловсруулалт хийх гэх мэт шинжилгээний өндөр ур чадвартай бизнесийн шинжээч тал руу чиглүүлбэл хөтөлбөрийн өрсөлдөх чадварт нөлөөлөх эсэхийг судалж үзэх;

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

1. Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
2. Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
3. Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн баримт материал

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго нь ХИС-ийн эрхэм зорилго, зорилтод бүрэн нийцсэн байна.
- Төгсөгчид болон суралцагчдын хэлний мэдлэг нь илүү давуу тал болдог.
- Төгсөгчдийн ажлын байран дээрх ахиц дэвшил харьцангуй хурдтай гэж уулзалтад оролцогсод ярьж байсан. Энд хувь хүний соёл, харилцааны хандлага их нөлөөтэй.
- 2014 ба 2019 оны төгсөгчидтэй хийсэн уулзалтаас харахад 5 жилийн дотор эдийн засгийн хөтөлбөрт ихээхэн өөрчлөлт орсон.
- Хөтөлбөрийн талаар оролцогч талуудад болон нийтэд мэдээлэх, сурталчлах ажил төлөвлөгөөний дагуу явагддаг.
- Эдийн засгийн хөтөлбөрийг дүүргэсэн оюутнууд банк, санхүүгийн байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэх талбар дээр хүчээ сорьж байгаа байдал ажиглагдаж байна.

Анхаарах асуудал:

- Эдийн засагч мэргэшлийн хүрээгээ нарийвчлан тогтоож, бизнес шинжээч үү, өгөдлийн шинжээч үү, эсвэл олон улсын эдийн засагч уу гэдгээс хамааран хөтөлбөрийнхөө зорилго, зорилтыг уялдуулан өөрчлөх эсэхэд анхаарах;

- Төгсөгчдийн 50 гаруй хувь нь хувийн хэвшилд ажиллаж байгаагаас харахад эдийн засгийн хөтөлбөр нь микро эдийн засгийн хичээлүүдэд төвлөрөх хандлага ажиглагдаж байгаа тул хөтөлбөрийн зорилго, зорилттой уялдуулах талыг анхаарах;
- Эдийн засгийн хөтөлбөрийн хүрээнд тодорхойлж буй зорилго ба зорилтуудын хооронд зарчмын ялгаатай тал ажиглагдаж байгааг анхаарах – зорилго нь эдийн засгийн онол, арга зүй, бодлого боловсруулах, шийдвэр гаргах гэх зэрэг эдийн засгийн шинжлэх ухааны хүрээг хамруулан хөтөлбөрийг дүүргэж байгаа гэдгийг харуулах бус, харин мэдэх ба хийх зүйлийн хольц байдалтай, харин зорилтууд нь гол төлөв чадварт анхаарал хандуулсан байгаад дүгнэлт хийж сайжруулах;
- Оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг Хөтөлбөрийн хороонд танилцуулдаг шаталсан арга хэмжээг зохион байгуулах;
- Хөтөлбөрийг сурталчлах талаарх ажлын үр дүнг нэгтгэн үзүүлэх талаар анхаарах;

Зөвлөмж:

- Төгсөгчдийнхөө давуу тал болох гадаад хэлний мэдлэгийг тасралтгүй дээшлүүлдэг байх зорилтоо бататгах
- Хөтөлбөрийн зорилгыг илүү нарийвчилж тодорхой болгох;
- Ажил олгогч, төгсөгчдийн өөртөө ажлын байр гаргах боломж, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж буй арга зүйгээ улам сайжруулж, тогтмол давтамжтай болгон явуулахад анхаарах;

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан хөтөлбөр,
- Хурлын тэмдэглэл
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээний зөвлөмжид тулгуурлан хөтөлбөр төлөвлөлтийн баримт бичгийг сайжруулах эхлэл тавигдсан;
- Бусад их сургуулиудтай эдийн засгийн хөтөлбөр ижил практикаар хэрэгжиж байна;

- Хөтөлбөрийн баримт бичиг нь ХИС-ийн Хөтөлбөрийн хороогоор батлагдсан;
- Хөтөлбөрийг сайжруулах үйл явц сүүлийн жилүүдэд эрчимжсэн;
- PLO болон CLO-ын матрицыг ашиглаж байгаа нь хөтөлбөрийн уялдааг хангах боломжийг бүрдүүлж эхэлсэн;
- Дадлагын хөтөлбөрт өөрчлөлт оруулахаар санаачилга эхэлж байгааг дэмжин ажиллах хандлага гарч эхэлсэн;

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээний зөвлөмжийн дагуу эдийн засгийн хөтөлбөр дэх сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээг хичээлийн тодорхойлолтой уялдуулж хэрэгжүүлэхэд анхаарах;
- Хөтөлбөрт эдийн засгийн мэргэжлийн хичээлүүд цөөн заагдаж байгааг анхаарах;

Зөвлөмж:

- Их сургуулийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн уялдаа холбоо, залгамж чанарыг нийцүүлэхэд анхаарах;
- Үр дүнд чиглэсэн арга зүйг сайжруулахын тулд оролцогч ба сонирхогч талуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарах;

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/

-Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын ACBSP байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүдийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн.
- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матрицыг ашиглаж эхэлсэн.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд шинжилгээ хийж үзэхэд их сургуулийн ерөнхий суурь, мэргэжлийн суурийн заавал болон сонгон судлах хичээл, мэргэжлийн заавал болон сонгон судлах хичээлүүд стандартчилагдсан, бусад эдийн засгийн хөтөлбөрүүдтэй ижил жишигтэй байна.

Анхаарах асуудал:

- Оюутны дадлагыг үр өгөөжтэй, хөтөлбөрийн зорилготой нягт уялдуулан зохион байгуулахад анхаарах;
- Хичээлийн тодорхойлолтыг удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулах;
- Батлагдсан хөтөлбөрийн хичээлийн индекс, хичээл хоорондын уялдаа холбоог хичээлийн улирлаар, оюутанд ойлгомжтой байдлаар зураглах;
- Мэргэжлийн болон танилцах дадлагыг үнэлэх арга зүйг илүү нарийвчлан сайжруулах;

Зөвлөмж:

- Хичээлүүдийн залгамж холбоо, уялдааг харуулсан хөтөлбөрийн модыг илүү тодорхой, ойлгомжтой болгох талаар ажиллах;
- Бизнесийн эдийн засгийн эрэлт хэрэгцээ өндөр болж байгаа тул эдийн засгийн хөтөлбөрийн сургалтын агуулгыг уялдуулан сайжруулах талаар судалж үзэх;
- Дадлагын бааз, түшиц газартай болох;
- ААН-тэй дадлагын ажил хийлгэх гэрээ, ойлголцлын санамж бичиг байгуулах талаар ХИС санаачилга гаргах;

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

-Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж

-Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын арга зүйн зохистой дадлыг нэвтрүүлж байгаа: суралцахуйн болон багшлахуйн арга зүй
- Тайлангаас харахад Монгол улсын хэмжээнд их, дээд сургуулиудын хэрэглэдэг заах арга зүйг бүрэн хэрэглэдэг.
- Хөтөлбөрийн зорилгод нийцсэн сургалтын арга зүйг төлөвшүүлж буй

Анхаарах асуудал:

- Сургалтын арга зүйг тогтмол судалж, үнэлж дүгнэх ажлыг тогтмолжуулах;
- Цогц чадамж нь PLO болон CLO-тай харилцан холбогдох байдалтай шууд, шууд бус, дам байдлаар холбогдож байгааг зааглаж харуулах;
- Хөтөлбөрийн багш нар эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнгээр сургалтын арга зүйгээ баяжуулахад анхаарах;
- Тэнхимийн багш нарыг бизнесийн болон төрийн байгууллагад дадлагажих боломжийг нээж, сургалтын арга зүйг хэрэглээ тал руу чиглүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- SWOT шинжилгээгээр гаргасан сул талуудыг арилгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг дэс дараатай хэрэгжүүлэх;
- Эдийн засгийн хөтөлбөрийн багш нар бизнесийн болон төрийн байгууллагатай хамтран ажиллах замаар сургалтын арга зүйг сайжруулах талаар сургуулийн удирдлага анхаарах,

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи, Рубрик арга г.м/
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, сурлагын амжилт, чанар гэх мэт/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тогтсон буюу дээд боловсролд хэвшсэн үнэлгээний арга зүйтэй.

Анхаарах асуудал:

- Сургалтын үнэлгээний аргуудад тогтмол давтамжтай шинжилгээг хийж, үнэлгээ нь бодитой, мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг аль болох бүрэн гүйцэд үнэлдэг байхад анхаарах. Энэ бол ХИС-ийн хэмжээний асуудал.
- Үнэлгээний рубрик нь хичээл бүрт нийтлэг, ижил, ойролцоо байх талаар анхаарах
- CLO үр дүнг хичээл, оюутан бүрээр гаргаж, шинжлэх боломжтой байгааг анхаарах;
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлтийг бүх оюутанд хүргэх хэрэглээний программыг улам боловсронгуй болгох;

Зөвлөмж:

- Сургалтын үнэлгээний аргуудад тогтмол давтамжтай шинжилгээг хийж, цаашдын ажилдаа бүрэн ашиглаж байхыг эрмэлзэх;
- Үнэлгээний рубрикийг хөтөлбөрийн хичээл бүрт ойролцоо, ижил болгох асуудлыг судлах;
- Сурлагын амжилтын талаарх статистик шинжилгээг нөлөөлж буй хүчин зүйлээр нь илүү нарийвчлан хийж судлах;

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: *Бүрэн хангасан*

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан

- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХИС нь хичээлийн 4 байртай, орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон анги танхим, биеийн тамирын заал, оюутны дотуур байртай сургалтын үйл ажиллагааг явуулж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай орчин, нөхцөл бүрдсэн, стандартад нийцсэн лаборатори, анги танхимтай, байнгын сайжруулалт хийгддэг.
- Мэдээллийн технологийн хүртээмж, цахим орчны ашиглалтын байдал сайн, сэтгэл ханамж өндөр байдаг.
- ХИС-ийн Эдийн засгийн хөтөлбөрийн нэр хүнд ажил олгогчдын дунд МУИС, СЭЗИС, Мандах их сургуулийн дараа 4-рт эрэмбэлэгдэж байгаа тухай төгсөгчид, ажил олгогчдын төлөөлөл тайлбарласан.
- Анги танхимын тохижилт, лабораторийн шинэчлэл нь сурах орчныг таатай болгож байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын ажиллах орчинг улам сайжруулах, өрөөний хангамжийг нэмэгдүүлэх талаар анхаарах;
- Анги танхимын тордолт арчилгаа, сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны шинэчлэлт нь байнгын ашиглалтын зардлыг ихэсгэж болзошгүй тул хэмнэлттэй технологийг ашиглах асуудлыг судлах;

Зөвлөмж:

- SWOT шинжилгээгээр гаргасан сул талуудыг арилгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг дэс дараатай хэрэгжүүлэх;
- Багшийн ажлын өрөөний хангамжийг нэмэгдүүлж, ажиллах таатай орчинг улам сайжруулах талаар авч буй арга хэмжээг дэс дараатайгаар үргэлжлүүлэх;
- Сургалтын онцлог орчныг нийтэд сурталчлах нь хөтөлбөрийн нэр хүндийг өсгөх талтай.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- E-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Ном сурах бичиг, гарын авлага гэх зэрэг сургалтын материаллаг орчин хангалттай бүрдсэн.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж гэх зэргийг онлайн хэлбэрээр оюутнуудад хүргэх болсон.
- Сургалт судалгааны программ хангамжийг зохих түвшинд бүрдүүлэн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт ашиглагдаж буй программ хангамжийн өөрчлөлт хурдацтай байгаа өнөөгийн нөхцөлд боломжит сувгуудыг хайж, хүртээмжийг нэмэгдүүлэх
- **Ном сурах бичиг, гарын авлагын зохиогчийн эрхийн асуудлыг анхаарах;**
- E-контенттэй сургалтын материал, хичээлийн багц бэлтгэхэд анхаарах;
- Сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах заавар, удирдамжийг оюутнууд хэрхэн ашиглаж байгааг судлахад анхаарах;
- Мэргэжлийн сэтгүүл, онлайн эх сурвалжийг зааж өгөх байдал, тэдгээрийг эдийн засгийн хөтөлбөрт байгаа хичээл тус бүрээр нарийвчлан гаргахад анхаарах;

Зөвлөмж:

- **Сургалтын хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх талаар тогтсон байдлыг цаашид бататган, улам өргөжүүлэх;**
- Багш нарын судалгааны ажилд хэрэглэх программ хангамжийг бусад сургууль, байгууллагатай хамтарсан байдлаар шийдвэрлэх арга замыг хайх;
- Сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах дэмжлэгийг тогтвортой хадгалах;
- Үндэсний болон гадаад сурах бичгийн ашиглалтын талаар харьцуулсан судалгаа хийх;

- Оюутныг сэдэлжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүнд шинэ зүйлс, тухайлбал, эдийн засаг ба хүмүүнлэгийн шинжлэх ухааныг дамнасан асуудал, жишээ, нөхцөл, баримт, бодлого дасгал түлхүү ашиглаж, хөтөлбөрийн онцлогийг ялгаатайгаар харуулах;

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

-Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа

-Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа

-Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн хангамж сайн;
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийг сүүлийн жилүүдэд эрчимтэй хийж байгаа;

Анхаарах асуудал:

- “Цахим номын сан” бүрдүүлэх, цахим нээлттэй эх үүсвэр ашиглах талаар журам, баримт бичгийг нэгтгэн гаргаж, мөрдөн ажиллахад анхаарах;
- Эдийн засгийн хөтөлбөртэй холбоотой олон улсын байгууллага болон донор байгууллагуудын судалгааны тайлангаар цахим мэдээллийн санг баяжуулах;
- Эдийн засгийн судалгаатай холбоотой цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн талаарх мэдлэг, мэдээлэл, ашиглалтын талаарх зааварчилгааг дэлгэрүүлэн түгээхэд анхаарах;

Зөвлөмж:

- Номын сангийн баяжилт хийж, багш, суралцагчдын сургалтад үзүүлж буй дэмжлэгийг улам өргөжүүлэн хадгалах;
- “Цахим номын сан” бүрдүүлэх, нээлттэй эх үүсвэр ашиглах талаар бусад их сургууль, судалгааны байгууллагуудтай хорших байдлаар шийдэх арга замыг хайх;
- **Багш нарын бүтээл, тэдгээрийн ашиглалтын эрх зүйн үндэслэлийг анхаарч үзэх;**

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: *Бүрэн хангасан*

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал: *Хэсэгчлэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- “Хөтөлбөрийн чанарын удирдлага”-ыг онцолж, хөтөлбөрийн асуудал эрхэлсэн дэд захиралтай болсон.
- Тэнхимийн эрхлэгч захиргааны албан тушаалтан болсон.

Анхаарах асуудал:

- Багш нарын цагийн ачаалал их байгаа нь сургалтын чанарт нөлөөлж байгаа эсэхийг судалж тогтоох;
- Сургалтын чанарын талаарх судалгаа, тайлангийн шинжилгээг тогтмолжуулж, үр дүнтэй болгоход анхаарах;
- СЭЗ-ийн тэнхим урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийх шинжилгээг тогтмолжуулах;

Зөвлөмж:

- Холбогдох төлөвлөгөө, тайланг гаргадаг ч түүнд хийсэн шинжилгээ, үр дүнг харуулах судалгаа тогтмолжоогүй байгаа тул анхааран ажиллах;

- Эдийн засгийн хөтөлбөр сургалт дангаараа, сургалт ба судалгаа, судалгаа дангаараа, сургалт ба туршилт, судалгаа ба туршилт гээд аль тал руу төвлөрөх талаар анхаарвал хөтөлбөрийн нэр хүнд нөлөөтэй болохыг харгалзаж үзэх;
- Эдийн засгийн хөтөлбөрийн профессорын багийг ажиллуулах боломжийг судлах;

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаад, дотоодын их сургууль, судалгааны байгууллага, холбогдох газруудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, үр дүнтэй ажиллаж байна.
- Суралцагчид, багш, ажилтны солилцоо, хамтарсан судалгааны ажлыг идэвхтэй хэрэгжүүлдэг.
- Оюутны сайн дурын, нийгмийн ажлыг дэмжиж, хэрэгжүүлэх тогтолцоо бүрдэж эхэлсэн.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг тогтмолжуулж, эргэх холбоог ашиглан хөтөлбөрийн удирдлагад оролцуулах боломжийг нэмэгдүүлэх;
- Төгсөгчдийг давтан сургах, хөтөлбөрийн өөрчлөлтийн талаарх мэдээллээр хангах ажлыг тогтмолжуулах;
- Эдийн засгийн хөтөлбөрийн багш, оюутны нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлтийг тогтмол хийж, үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах ажлыг хэрэгжүүлэх;

- Эдийн засгийн хөтөлбөрийн багш нарын дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож ажиллах талаарх туршлага бага; багш нарын солилцооны хөтөлбөр, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөрт оролцох байдал сул байгааг анхаарах;
- Бие даан болон хамтран хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр СЭЗ-ийн тэнхимд харьцангуй бага байгааг анхаарах;

Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбоог идэвхжүүлж, ажлыг тогтмолжуулах тодорхой үйл ажиллагааг зохион байгуулах талаар судалж, шийдвэрлэх;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш, оюутны нийгмийн үйлчилгээний ажлыг үнэлэх, үр дүнг бүртгэх, мэдээлэх ажил нийтийн дунд бүрхэгдэх байдалтай байгааг өөрчлөх ажлыг зохион байгуулах;
- Эдийн засгийн хөтөлбөрийн багш нарын дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож, эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар хамтрахад Бизнесийн сургууль болон ХИС санаачилга гарган, дэмжин ажиллах;

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан

-Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо

-Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа

-Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт

-Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн жилийн төсөв, зарцуулалтыг ХИС-ийн хэмжээгээр нэгтгэн төлөвлөж, хэрэгжүүлдэг.
- Нэг оюутанд ногдох өртөг, зардлын тооцоог хийдэг.
- Батлагдсан төсвийн дагуу холбогдох зүйлд зарцуулахад саад бэрхшээл бага.

Анхаарах асуудал:

- Хэдийгээр төсвийн нэгдсэн тогтолцоотой ч гэсэн хөтөлбөрийн орлого, зарлагын тооцоог хийж, шинжилгээ явуулах үндсэн дээр хөтөлбөрийн үр ашиг, өгөөжийн мэдээллийг тогтмол гаргаж байхад анхаарах;
- Багш, оюутны хөгжлийг дэмжих зорилгоор хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийн өөр, олон сувгийг эрж хайхад анхаарах;
- Эдийн засгийн хөтөлбөрийг бэхжүүлэх, үйлдвэрлэл ба шинжлэх ухааны холбоосыг дэмжих талаас гадаад, дотоодын судалгааны санхүүжилт татах асуудлыг анхааралдаа авах;

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх үүднээс орлогын өөр эх үүсвэрийг бий болгоход тэнхимийн зүгээс ч анхаарч, ХИС, Бизнесийн сургуультайгаа хамтран хэрэгжүүлэх санаачлага гаргах
- ХИС-ийн зүгээс хөтөлбөрийн санхүүжилтийн талаар тусгай журам гаргаж, нэмэлт орлогын тодорхой хувийг захиран зарцуулах эрхийг олгох талаар судалж үзэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

-Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал

-Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөг ХИС-ийн хэмжээгээр нэгтгэн явуулдаг.
- Элсэлтийн нэгдсэн бодлоготой, жил бүр элсэлтийн талаарх сурталчилгаа, мэдээллийн баримт бичгийг боловсруулж, баталдаг.
- Сурталчлан таниулах ажлыг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хувьд идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөг гаргаж хэвшүүлэх, хэрэгжилтийг зохион явуулахад анхаарах;
- Маркетингийн 7P, 5C өөр бусад холбоотой асуудлын хүрээгээр Эдийн засгийн хөтөлбөрийг шинжилж, хэрэглэгчдийг татах сувгаа бэхжүүлэхэд анхаарах;

Зөвлөмж:

- Сургуулийн нэр хүндийг өсгөхөд Эдийн засгийн хөтөлбөрийн гүйцэтгэх үүргийг илүү тодорхой болгох;
- Сургууль нэгдсэн байдлаар шийдвэрлэдэг гэсэн хандлагаар хөтөлбөрийн маркетингийн ажлыг бүрхэгдүүлдэг, зарим талаар орхигдуулдаг байдлыг засах ажлыг зохион байгуулахад анхаарах;

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн хэмжээгээр үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд мэдээлэл түгээх тогтолцоог бүрдүүлж чадсан байна.
- Мэдээллийн сувгуудыг боломжит хэмжээгээр ашигладаг.
- Олон жилийн туршлагатай, “улсын” сургууль байсан гэдэг нэр хүнд уламжлагдан ирсэн.
- ХИС-ийг олон нийт “гадаад хэлний” гэдэг тодотголоор илүү ханддаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн талаарх мэдээллийг түгээх, идэвхжүүлэх ажлыг нэгдсэн арга хэмжээний хажуугаар, тусад нь явуулах боломжийг судлах талаар анхаарах;
- Эдийн засгийн хөтөлбөрийг сургуулийн уламжлалт байдлыг хадгалахтай холбоход анхаарал хандуулах;
- Чанарын удирдлагын тогтолцоогоо олон нийтэд таниулах ажлыг эрчимжүүлэх;
- **Эдийн засгийн хөтөлбөрт шууд нөлөө үзүүлэх боломж байгааг анхаарах;**

Зөвлөмж:

- ХИС-ийн Эдийн засгийн хөтөлбөрийн талаарх олон нийтийн түгээмэл ойлголтыг хэвээр хадгалах, эсвэл өөрчилж шинэчлэх асуудлыг нарийвчлан судлах;

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: *Бүрэн хангасан*

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

-Элсэлтийн бодлого, дүрэм журам. “Хүмүүнлэгийн Их Сургуулийн элсэлтийн журам”-г баримталдаг.

-Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа. Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо 2016 онд 400, 2017, 2018 онд 450 байна. Нийт сонирхогчдын буюу элсэлтийн системд бүртгүүлэгчдийн 8.5 хувь нь эдийн засгийн хөтөлбөрт элсэн суралцаж байна.

-Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага. Шинээр элсэгчдэд зориулан 8 сард чиглүүлэх сургалт зохион байгуулж, мэдээлэл өгдөг. 2017 оноос эхлэн Мэдээлэл, технологийн албанаас сургалт зохион байгуулж, “Элсэгчдэд зориулсан гарын авлага”-г сургуулийн вэбэд байршуулан үйлчилгээ үзүүлж байна. (<http://www.humanities.mn/page/3756>)

-Гадаад оюутны элсэлтийн тоо - байхгүй

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэлтийн бодлогыг хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан хийж байна.
- Шинээр элсэгчдэд зориулан 8 сард чиглүүлэх сургалт зохион байгуулж, мэдээлэл өгдөг байна.

Анхаарах асуудал:

- Элсэгчдэд тавигдах босго оноог эдийн засгийн хөтөлбөрийн хувьд өндөрсгөх талаар анхаарах;
- “Оюутны ном” гарын авлага байдаг боловч, хэрэглээ нь тогтмолжоогүй байгааг анхаарах;

Зөвлөмж:

- Эдийн засгийн хөтөлбөрийн элсэгчдийн квотыг нэмэгдүүлэх талаар санал боловсруулан холбогдох удирдлагад танилцуулах;
- Хөтөлбөрт элсэгчдийн босго оноог нэмэгдүүлэх талаар судалж үзэх;

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

-Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан. Багш бүр жилийн ажлын төлөвлөгөөнд оюутанд зөвлөн туслах үйлчилгээг В цагийн хүрээнд төлөвлөн ажилладаг. Нэг багш долоо хоногт 4 цаг оюутанд үйлчилгээ үзүүлэх хуваарийн дагуу ажилладаг. Зөвлөх багш болон бүх түвшний ажилтан, удирдах ажилтнууд нь хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж, жилд хоёр удаа үйл ажиллагааны тайлангийн хэрэгжилтийн тайлан бичиж, холбогдох албан тушаалтнууд үнэлгээ өгч ажилладаг.

-Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал. Улирал бүрийн төгсгөлд суралцагчид судалсан хичээлүүд, сургуулийн алба, ажилчдын үйл ажиллагааны тухай сэтгэл ханамжийн судалгааг оюутны программаар дамжуулан үнэлдэг. Судалгааны үр дүн нь тухайн багш, ажилтнуудад шууд харагдах бөгөөд холбогдох удирдлага нь үр дүнд тулгуурлан зөвлөмж, заавар өгөх байдлаар ажиллаж байна.

-Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ. Сургалтын хөтөлбөрт Хүний хөгжил-3 кр, Экологи ба тогтвортой хөгжил- 3 кр, Биеийн тамир, эрүүл ахуй-1 кр орж байна. Оюутны холбоо, ОХЭДТ-с жил бүр тогтмол явуулдаг үйл ажиллагаануудаас “Миний мэргэжлийн ач тус”, “Хөдөлмөрийн харилцаа” сургалтууд тогтмол явагдаж хэвшжээ.

-Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ. Жил бүрийн 4 сард ХИС-ийн Оюутны ЭШБХ зохион байгуулагдаж хэвшсэн ч, Эдийн засгийн хөтөлбөрийн хувьд 2 жилийн өмнөөс эхлэн зохион байгуулж байгаа юм байна. Сургуулийн зүгээс www.jstor.org, www.sciencedirect.com мэргэжлийн сэтгүүлийн хандах эрхийг худалдан авч суралцагчдад судалгааны ажлын дэмжлэг үзүүлдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын талаарх удирдамж, зөвлөмжийг онлайн хэлбэрээр хүргэдэг.
- Суралцагчдад мэргэжлийн сэтгүүлийн хандах эрхийг хэрэглүүлж хэвшсэн.
- Зөвлөх багш ажиллуулж, суралцагч нэг бүртэй тулж ажиллах тогтолцоог хэрэгжүүлдэг.
- ОХЭДТ ажиллуулж, суралцагчдыг цагийн ажилд зуучлах, нийгмийн ажилд хамруулах ажил зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Ахлах түвшний оюутнуудыг бага түвшний оюутанд зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах боломжтойг анхаарах;
- Удирдлагын мэдээллийн нэгдсэн системийн хэрэглээг оюутанд илүү ойлгомжтой болгож, зөвлөх багшийн ажлын ачааллыг бууруулахад анхаарах;
- Сэтгэл ханамжийн судалгаа хийгдэж байгаа ч, асуулгын үр дүнгийн дагуу бодитоор хийсэн ажлын тайлан хангалттай бус байгааг анхаарах;

Зөвлөмж:

- Тьюторын тогтолцоог хэрэгжүүлэх, ахлах ангийн оюутанд урамшуулал, эсвэл, кредит тооцож болох эсэхийг судалж үзэх;
- Оюутны дунд зохион байгуулдаг судалгааны хэлэлцүүлэг, мэтгэлцээн, тайлангийн хурлыг тогтмолжуулах;
- Хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын ЭШБХуралд оролцох боломжийг нэмэгдүүлж, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх;
- Бусад сургуулиудтай хамтран ажиллах, хүрээгээ тэлэх тал дээр анхаарч ажиллах;

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

-Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ. Суралцагчид оюутны холбоо, оюутны клубүүдээр дамжуулан сайн дурын үйл ажиллагаанд оролцдог. ОХЭДТөв нь 2015 онд байгуулагдан үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна.

-Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал

-Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл. Оюутнууд зуучлуулахаар мэдээллээ өгсөн байгаа боловч, одоогоор ажил олгогчдын зүгээс тодорхой хариу аваагүй байна.

-Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл

-Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо. “Сургалтын төлбөр тооцооны журам-4.2.1, 4.2.3, 4.2.5-д ЭЕШ-н онооноос хамааран сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэхээс гадна, голч дүнгийн үнэлгээнээс хамааран 4-10 хувийн хөнгөлөлт авах эрхтэйгээр үйлчлүүлдэг байна. 2016-2017 онд 24 оюутан төлбөрөө бүрэн төлж 2929.1, 2017-2018 онд ЭЕШ-н өндөр оноотой болон голч дүн өндөртэй 26 оюутан 2174.1 мянган төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОХЭДТ-ийн үйл ажиллагааг сургуулийн удирдлагын зүгээс зөв зохион байгуулж, үйл ажиллагаа нь хэвшсэн.
- Оюутны клубүүдийг дэмжих тодорхой төсвийг баталж өгдөг.

Анхаарах асуудал:

- Оюутны нийгмийн ажлыг зөвхөн клубын ажлаар хязгаарлахгүй, хувь оюутны идэвхийг өрнүүлэх, сэдлийг төрүүлэх хөшүүрэг бий болгоход анхаарах;
- ОХЭДТөв, Оюутны холбоо, клубүүд нь хийсэн ажлынхаа тайлан, үр дүнг олон нийтэд, ил тод, тодорхой ойлгомжтой байдлаар нэгтгэн мэдээлэх ажлыг тогтмолжуулах;

Зөвлөмж:

- Оюутныг нийгмийн ажилд оролцох, сайн дурын ажил хийх тэдний сэдлийг идэвхжүүлэхийн тулд кредит цаг тооцох боломжийг судалж үзэх;
- Оюутны клуб, сайн дурын байгууллагын үйл ажиллагааг тогтмолжуулахад тодорхой хөшүүрэг хэрэглэх;
- Олон нийтийн байгууллагын тэтгэлэгт хөтөлбөр, төслийн уралдаан гэх мэт үйл ажиллагаанд оюутнуудыг сэдэлжүүлж оролцуулах явдлыг өргөжүүлэх;

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

-Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа. 2014-2018 оны хичээлийн жилүүдэд 11 оюутан жилийн чөлөө болон улирч орж ирсэн бол 42 оюутан шилжиж ирсэн, эсвэл шинээр элссэн байна.

-Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам. ХИС-ийн 2018 онд батлагдсан “Дээд боловсролын зэрэг олгох сургалтын журам”-аар зохицуулагдаж, шилжин суралцах хүсэлтэй оюутнууд урьдчилан хандаж, зөрүү хичээлүүд болон суралцах түвшингээ тогтоолгож, сургалтын талаар зөвлөгөө, мэдээлэл авдаг болсон нь суралцагчдад давуу талуудыг бий болгожээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2014-2018 оны хичээлийн жилүүдэд тус хөтөлбөрөөс өөр сургууль руу оюутан шилжих болон орхин яваагүй байна.

Анхаарах асуудал:

- Бусад их сургуультай харилцан кредит тооцох тухай санамж бичиг байгуулах боломжийг анхаарах;
- Заавал оюутан шилжин суралцах гэхээс илүүтэй, өөр сургуулийн оюутан ч тус хөтөлбөрийн хичээлийг сонгон суралцах боломжийг нээлттэй болгох талаар судлах;

Зөвлөмж:

- Бусад сургуулийн оюутан тус хөтөлбөрийн хичээлээс сонгон суралцах болон тус хөтөлбөрийн оюутан өөр сургуулийн хичээл сонгон суралцах боломжийг судалж үзэх;
- Шилжилт хөдөлгөөний талаарх судалгааг нарийвчлан хийж, тогтмолжуулах;

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

-Төгсөлтийн баримт бичгийн загвар. ХИС-ийн 2018 онд батлагдсан “Дээд боловсролын зэрэг олгох сургалтын журам”-аар зохицуулагдаж, төгсөгчдийн дүнгийн хуулбар Мэдээллийн санд орохын зэрэгцээ, сургуулийн архив бичиг хэрэгт мөн хадгалагдан үлддэг.

-Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал. Журмын дагуу олгож хэвшсэн.

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичгийг холбогдох дээд байгууллагын баталсан дүрэм, зааврын дагуу хийдэг.
- Сургуулийн мэдээллийн нэгдсэн санд төгсөгчдийн мэдээлэл бүрэн орсон.
- Элсэлтийн бодлогыг хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан хийж байна.
- Гадаад хэлний эрэлт ихтэй тул элсэгчид сонгож орж ирдэг.
- Эдийн засгийн хөтөлбөрөөс бусад сургууль руу шилжсэн оюутан байхгүй.

Анхаарах асуудал:

- Төгсөлтийн баримт бичиг дээр эзэмшсэн мэргэжил, мэргэшлийг БСШУСЯ-ны холбогдох журмын дагуу бичиж байгаа ч, төгсөгчдийн өөрсдийн хэлж буйтай зөрөх тохиолдол байгааг анхаарах;
- Төгсөгчдийн, хөтөлбөрийн үр дүнг харуулах төгсөлтийн ажил болон нэгдсэн шалгалтын байдалд дүн шинжилгээ хийхэд анхаарах;

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: *Бүрэн хангасан*

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

-Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан. ХИС-ийн Хүний нөөцийн эрхзүйн орчин нь 2015 оны байдлаар байвал зохих 10 үндсэн баримт бичгүүдээс бүрдсэн байна. “ХИС-ийн Стратеги төлөвлөгөө 2010-2020”-ийн 2014-2017 оны биелэлтийн үнэлгээгээр Хүний нөөцийн чиглэл 91 хувиар хоёрдугаарт орсон байна.

-Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/. Бизнесийн сургуулийн нийт багш нарын 23.3 хувь нь доктор, түүнээс дээш зэрэг, цолтой багш нар байна. Докторын зэрэгтэй багшийн тоо 2014-2018 онд өссөн харагдаж байгаа ч, нийт багшид эзлэх хувийн жингээр үзвэл өсөлт харагдахгүй байна.

-Багш, суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэг багшид ноогдох суралцагчийн тоо 2014-2016 онд өндөр байсан ч, 2017-2018 онд багшийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор багш, суралцагчдын тооны харьцаа зохистой хэмжээнд байна.

-Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа. 2018 оны байдлаар 1 багш дэд профессорын зэрэглэлд, 7 багш ахлах багшийн зэрэглэлд ахиж ажилласан байна.

-Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа. Нэг багшийн ачаалал 35.5 кр. Багшийн зэрэглэлийн түвшнээсээ хамаараад А, Б, В цагууд нь ялгаатай.

-Багш нарт олгосон урамшууллын судалгаа. Докторант багш нарт зориулж сургалтын төлбөрийн 50, 30 хувийн хөнгөлөлт үзүүлдэг. 2013 оноос эхлэн эдийн засгийн тэнхимийн 7 багшид сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлсэн байна. Докторын болон эрдмийн зэргийн нэмэгдэл 15-20 хувь, ажлын байртай холбоотой мэргэжлийн нэмэгдэл 2.5 хувиар, Докторын зэрэг хамгаалахад нэг удаад 300.000 төгрөг олгодог байна. Мөн илүү цагийн хөлсийг зөвхөн 2018 онд 12 багшид олгосон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “ХИС-ийн Стратеги төлөвлөгөө 2010-2020”-ийн 2014-2017 оны биелэлтийн үнэлгээгээр Хүний нөөцийн чиглэл 91 хувиар хоёрдугаарт орсон байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар харьцангуй залуу, шинэ багш нар байгаа тул албан тушаалын зэрэглэл хурдан хугацаанд ахих боломжийг судлахад анхаарах;
- Эдийн засгийн хөтөлбөрт багшийг сонгон шалгаруулж авахдаа эрдмийн зэрэг, цолыг харгалзан үзэх талаар анхаарах;

Зөвлөмж:

- Эрдмийн зэрэггүй багшийг дэд профессорын орон тоон дээр ажиллуулж байгааг эргэж харах;
- Багшийн ажлын зэрэглэлийн талаарх журмыг шинэчлэн сайжруулах талаар судлах;

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

-Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт. Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг Гүйцэтгэлийн үнэлгээний баг багш бүрийн ажлыг олон улсын жишиг загварын дагуу үнэлдэг байна.

-Төлөвлөгөө, тайлан. Багшийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 13 багш 33 удаа дотоод, гадаадад судалгааны ажил хийж, Олон улсын ЭШБХуралд оролцож, туршлага судлан, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байна.

-Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хувьд Эрдмийн зэрэгтэй багш байхгүй.
- Хөтөлбөрийн багш нараас бие даасан төсөл, хөтөлбөр удирддаг хүн байхгүй.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн багш нарын дунд эрдмийн зэрэгтэй хүн байхгүй байгааг анхаарч ойрын хугацаанд эрдмийн зэрэгтэй болох ажилд дэмжлэг үзүүлэх;
- БС-ийн хувьд Докторантын сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг давхардсан тоогоор 7 хүн, доктор хамгаалж нэг удаагийн урамшуулал авсан хүний тоо 1 байгаа ч, эдийн засгийн хөтөлбөрийн хувьд 4 багш хөнгөлөлт авсан байгааг анхаарах;
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх боломжийг нэмэгдүүлэх;

Зөвлөмж:

- Зөвлөх багшийн цагийг ахлах түвшний оюутнаар гүйцэтгүүлэх талаар судалж, санал боловсруулах;
- Багш нарын эрдмийн зэрэг хамгаалах ажлыг дэмжиж, ажлын ачааллыг зохицуулах талаар судалж, хэрэгжүүлэх;
- Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин, суралцах хэрэгцээг тодорхойлох судалгаа хийдэг байх;
- Багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих орчин, нөхцөлийг бүрдүүлэх;
- Багш нарт судалгааны арга зүй эзэмшүүлэх, төсөл хөтөлбөрт хэрхэн хамрагдах, гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах талаарх чиглүүлэх, мэдээлэх, сургалт зохион байгуулах;

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгаа. Бизнесийн сургуулийн хамт олон сүүлийн таван жилд 10 оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэсэн байна.
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам. Боловсруулсан бодлогын баримт бичиг, дотоод дүрэм журам маш хангалттай.

- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал. Бизнесийн сургуулийн хэмжээнд захиалгат болон гэрээт 57 ажилд удирдагч болон гүйцэтгэгчээр ажиллажээ. Мөн дотоодод 68, олон улсын хэмжээнд 27 судалгааны бүтээл хэвлэгдсэн байна.
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо. Багш нарын ЭШБХ-ын илтгэлүүдийг эмхэтгэл болгож “Эрдэм шинжилгээний бичиг” сэтгүүлийг хэвлэж хэвшсэн.
- Зарцуулсан төсөв, тайлан. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд сургуулийн жилийн төсвийн 0.5-1.3 хувийг зарцуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын бүтээл болох ном сурах бичиг, гарын авлагыг оюуны өмчийн газарт бүртгүүлж, гэрчилгээ авсан.
- “Эрдэм шинжилгээний бичиг” хэвлүүлж, багш нарын бүтээлийг нийтийн хүртээл болгодог.
- Эрдэм шинжилгээний хурал тогтмолжсон.

Анхаарах асуудал:

- Багш нарын зэрэглэлд эрдэм шинжилгээний ажлын цаг хэр оновчтой тогтоосныг эргэж судалж үзэх;
- Хөтөлбөрийн багш нарын эрдмийн зэргийн хамгаалалтыг хурдавчлах ажлыг дэмжих;
- Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшинг ахиулах хэрэгцээг тодорхойлох судалгаа хийдэг байх;
- Шинжлэх ухаан, технологийн сангийн нээлттэй төслүүдэд оролцох талаар анхаарах;
- Мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжлгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэхэд анхаарах;
- Сүүлийн 3 жилд гадаадын хамтарсан төсөл, судалгааны ажил хийгдээгүй байгааг анхаарч ажиллах;
- Олон улсын болон, үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж хэвших;

Зөвлөмж:

- Багш нарын эрдмийн зэргийн хамгаалалтыг дэмжиж, богино хугацаанд хамгаалуулах ажил зохион байгуулах боломжийг судлах;

- Гадаадын судалгааны сэтгүүлд бүтээл хэвлүүлэхийг бодлогоор, тодорхой хөшүүрэгтэйгээр дэмжиж ажиллах;
- ЭШ, судалгааны ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөр, төрөөс санхүүжилт авах боломжийг бодлогоор чиглүүлж ажиллах;
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг бизнесийн судалгаагаар өргөжүүлэх;

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

-Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан. Өмнөх жилүүдэд багшийг аттестатчиллаар үнэлдэг байсан бол, 2017 оноос эхлэн төлөвлөгөөний биелэлт, А,Б,В цагийн гүйцэтгэл, чанар зэргийг харгалзан тооцдог гүйцэтгэлийн үнэлгээний системийг нэвтрүүлэн ажиллаж байна.

-Багшийн өөрийн үнэлгээний тайлан. Багшийн ажлын төлөвлөгөөний биелэлтийн тайланд нийтлэг тусгагдсан дутагдлын дагуу арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн олон ажлууд байна.

-Хөндлөнгийн үнэлгээний дүн. <http://student.humanities.mn> оюутны вэбээр дамжуулан багшийн хөндлөнгийн үнэлгээг хийдэг. Оюутны сэтгэл ханамжийн судалгааны хөтөлбөртэй холбоотой санал асуулгад дунджаар 4.51 гэсэн үнэлгээг өгсөн нь өмнөх судалгаануудаас 0.05, 0.03 нэгжээр өссөн байна.

-Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан мэдээ. Дээрх үнэлгээнд тулгуурлан багшийн ур чадварыг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж гаргаж багшид танилцуулдаг.

-Багшийн хавтас. Тэнхим, багшид шаардлагатай материалууд тусгагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг жилд хоёр удаа хэлэлцэн ажлаа дүгнэдэг.

Анхаарах асуудал:

- Багшийн ажлын үнэлгээний системийг оновчтой болгон сайжруулахад анхаарах;
- Багшийн ажлын бүтэц, тэрэнд тохирсон үнэлгээний дагуу цалин хөлс, урамшуулал олгох тогтолцоог улам төгөлдөржүүлэх;
- Тэнхим хоорондын болон хөтөлбөр хоорондын багшийн цагийн ачааллыг оновчтой тогтооход анхаарах;

Зөвлөмж:

- Багш албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлагын үзүүлэлтийг боловсронгуй болгох;
- Багш нарыг төсөл хөтөлбөрт оролцож, нэмэлт орлогын эх үүсвэр бий болгох боломжийг бодлогоор дэмжих;
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх, хөгжлийн ажлыг чанаржуулах;

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: *Хэсэгчлэн хангасан*

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

-Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хариуцах үндсэн нэгж нь хөтөлбөрийн хороо юм.

-Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ. Хөтөлбөрийн төлөвлөлтийг хөтөлбөрийн хороо, хэрэгжүүлэлтийг хөтөлбөрийн хороо, гадаад оролцогчид, багшлах боловсон хүчин, хөтөлбөрийн үнэлгээ, сайжруулалтыг хөтөлбөрийн хороо, салбар сургууль, тэнхим хариуцан тасралтгүй сайжруулалт хийдэг.

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ. Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтанд төгсөгчид, ажил олгогчдын төлөөллөөс давуу болон сул талын талаар санал асуулга авч, санал зөвлөмжийг тусгадаг. Ажил олгогчдын судалгааг ОХЭДТ-с жил бүр хийж хэвшсэн байна. Энэ тайлангийн үр дүнгээс харахад мэргэжлийн ур чадвар, төсөл боловсруулах ур чадварыг 91 хувь гэж үнэлсэн байна. Мөн төгсөгчдөөс авсан санал асуулгын үр дүнгээр мэргэжлийн англи хэлийг чухал ур чадварт тооцдог тул мэргэжлийн хичээлийг англи хэл дээр заах өөрчлөлтийг хийсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: *Хэсэгчлэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- “Хөтөлбөрийн чанарын удирдлага”-ыг онцолж, хөтөлбөрийн асуудал эрхэлсэн дэд захиралтай болсон.
- Захирлын 2015 оны 11 сарын 11-ий өдрийн 712 тоот тушаалын дагуу “Хөтөлбөрийн дотоод чанарын үнэлгээний стандарт, үзүүлэлтүүд” бодлогын баримт бичиг боловсруулж ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- 2015 онд батлагдсан “хөтөлбөрийн дотоод чанарын үнэлгээний стандарт, үзүүлэлтүүд” баримт бичиг нь хуучирсан, одоогийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тохиромжгүй байгааг анхаарах;
- Эдийн засгийн хөтөлбөрийн ХИС болон БС-ийн бусад хөтөлбөртэй харьцуулсан эрэмблэлийг тогтоох ажлыг тогтмолжуулан, ил тод мэдээлдэг байх;

Зөвлөмж:

- Чанарын дотоод баталгаажилттай холбогдох баримт бичгийг шинэчлэн сайжруулах шаардлагатай;
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын үйл ажиллагааг эдийн засгийн хөтөлбөрийн нэгжийн түвшинд тогтмолжуулж, сайжруулалтыг тасралтгүй явуулах боломжийг өргөтгөх;
- Хөтөлбөрийн ялгарах онцлог, өрсөлдөх чадварыг оновчтой тодорхойлох;
- Дотоод аудитын үнэлгээг хөтөлбөрийн нэгжид тогтмол мэдээлж, эргэх холбоотой байхад анхаарах;

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

-Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн. Хөдөлмөр эрхэлж буй нийт төгсөгчдийн 57 хувь нь мэргэжлээрээ, 43 хувь нь мэргэжлээрээ бус ажиллаж байна. Тайлант хугацаанд төгсөгчдийн 47 хувь нь хувийн байгууллагад, 12 хувь нь хувиараа бизнес эрхлэгч, 10 хувь төрийн байгууллага, 8 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагад, 12 хувь нь үргэлжлүүлэн суралцаж, 10 хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна. Судалгаанд оролцсон төгсөгчдийн ажилгүйдлийн шалтгааныг тодруулахад 40 хувь нь хүүхэд төрүүлсэн, 55 хувь нь үргэлжлүүлэн суралцсан бөгөөд одоо ажил хайж байгаа, 5 хувь нь ажил идэвхтэй хайж

байна. Дахин суралцаж байгаа төгсөгчдийн 92 хувь нь өөр мэргэжлээр, 8 хувь нь үндсэн мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцаж байна.

-Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн. Төгсөгчдийн банк, санхүү, даатгалын байгууллагад ажиллах хэмжээ 58 хувьд хүрч өссөн бол хувийн байгууллагад ажиллах хэмжээ 16 хувь болж буурсан байна. Төгсөгчдийг ажилд орсон хугацаагаар нь авч үзвэл сурч байх хугацаандаа 2%, төгсөөд шууд ажилд орсон 7%, 6 сарын дотор 51%, 1 жилийн дотор 4%, 1.5 жилийн дотор 10%, үлдсэн хувь нь 2 жилийн дотор ажилд оржээ.

-Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ. Хөтөлбөрийн хувьд бүхэлд нь авч үзвэл нийт төгсөгчдийн 61 хувь нь төгсөөд 6 сарын дотор ажилд орсон судалгааны үр дүн гарчээ.

-Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/. Ажил олгогчдын судалгааг ОХЭДТ-с жил бүр хийж хэвшсэн байна. Энэ тайлангийн үр дүнгээс харахад мэргэжлийн ур чадвар, төсөл боловсруулах ур чадварыг 91 хувь гэж үнэлсэн байна. Мөн төгсөгчдөөс авсан санал асуулгын үр дүнгээр мэргэжлийн англи хэлийг чухал ур чадварт тооцдог тул мэргэжлийн хичээлийг англи хэлээр заах өөрчлөлтийг хийж эхэлсэн байна.

-Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн мэргэжлийн талаарх ойлголт, сэтгэл ханамж, хэрэгцээтэй байдлын талаар авсан асуулгад оролцогчдын 88 хувь нь сэтгэл ханамжтай, 12 хувь нь дунд болон бага гэсэн үнэлгээ өгсөн байна. Сэтгэл ханамж өндөр байгаа төгсөгчдийн хувьд багш нарын ур чадвар, хичээлийн хөтөлбөр зэрэгтэй холбоотойгоор тайлбар өгсөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн хичээлийг англи хэлээр заах өөрчлөлтийг хийж эхэлсэн байна.

Анхаарах асуудал:

- Оролцогч талуудаас авсан судалгааны үр дүнгээс гарсан саналыг тусган хөтөлбөрийг байнга сайжруулах ажлыг хэрэгжүүлэх;
- Төгсөгчид, ажил олгогчидтой эргэх холбоог сайжруулах тогтолцоог бүрдүүлэн, ажлыг тогтмолжуулах;
- Суралцах хугацаанд олгосон чадваруудаас компьютер, интернет ашиглах болон бичгээр тайлагнах чадварыг 0.9-1.3 хувь нь муу олгосон гэж үзсэн тул энэ талын чадвар олгох тал дээр анхаарал хандуулах;

Зөвлөмж:

- Төгсөгчдийн судалгаанаас гарсан үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах механизм, эргэж мэдээлэх тогтолцоог бий болгох талаар судалж үзэх;
- Магадлан итгэмжлэлд зориулсан судалгаа гэхээс илүүтэй хөтөлбөрийн байнгын сайжралт, үр дүнгийн дээшлэлттэй холбоотойгоор тогтмолжуулж явуулахад анхаарах;
- Хөдөлмөрийн зах зээл дээр шаардагдах ур чадваруудыг олон төрлөөр үнэлэх. Үүний тулд ажил олгогчид, хөдөлмөр зуучлалын төв, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах;

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

-Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр. Бизнесийн удирдлагын хөтөлбөрүүд нь ACBSP-ийн олон улсын магадлан итгэмжлэлийн зөвлөлөөр 2017-2018 оны хичээлийн жилд магадлан итгэмжлэгдсэн. Эдийн засаг хөтөлбөрийн хувьд магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны хүрээнд бүх хичээлийн хөтөлбөр болон сургалтын хөтөлбөрт (CPC) үнэлгээ хийсэн.

-Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрсөнийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/. Хөтөлбөрөөр төгсөгчид салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эсэхийг нотлох гол үзүүлэлт нь төгсөөд мэргэжлээрээ ямар хугацаанд ажилд орж чадсан бэ, ажилд ороод албан тушаал ахисан эсэх зэрэг үзүүлэлтээр хэмждэг.

-Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ.

-Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь. Хөтөлбөрийн хувьд бүхэлд нь авч үзвэл нийт төгсөгчдийн 61 хувь нь төгсөөд 6 сарын дотор ажилд орсон судалгааны үр дүн гарчээ. Сүүлийн 5 жилд эдийн засгийн төгсөгчдөөс 14 нь үргэлжлүүлэн суралцаж байгаа бол тэдний 7 нь гадаадын их, дээд сургуульд, 5 нь ХИС-д, 2 нь дотоодын бусад их, дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дотоодын магадлан итгэмжлэл хийх бэлтгэл ажлыг хангасан.
- Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн “Чанарын удирдлагын бүтэц”-ийг эхлэлтийн байдалтай ч гэсэн амжилттай хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг төгсөгчид нь дотоод, гадаадын дараагийн шатны сургалтад үргэлжлүүлэн суралцаж буй байдлын талаар судалж, үнэлэлт дүгнэлт байнга хийхэд анхаарах;
- Оролцогч бүх талуудтай хамтран хөтөлбөрийн үр дүнг сайжруулах ажлыг өргөнөөр явуулж байхад анхаарах;
- Боловсруулсан бодлогын бичиг баримт, ажлын төлөвлөгөөг эдийн засгийн хөтөлбөрийн нэгж дээр бодитой хэрэгжүүлэх тал дээр цаашид анхаарах;

Зөвлөмж:

- Төгсөгчидтэй холбоотой зохих судалгааг хийж, үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх байдалд үнэлгээ хийхэд анхаарах;
- Мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцагсдын хувийг нэмэгдүүлэх талаар санал боловсруулах;
- Эдийн засгийн мэргэжлийн төгсөгчдийн холбооны ажлыг тогтмолжуулж, үр өгөөжтэй болгоход анхаарах;

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: *Бүрэн хангасан*

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	2	1		2.2. Хэсэгчлэн хангасан. Зарим нотлох баримт хангалттай биш
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	3	2		4.1, 4.2 Хэсэгчлэн хангасан. Хөтөлбөрийн багш, оюутны нийгмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, бүртгэх, үнэлэх тогтолцоог бүрдүүлэх
5	Суралцагчид чиглэсэн үйлчилгээ	5			
6	Багшлах бүрэлдэхүүн	1	3		6.2, 6.3, 6.4 Хэсэгчлэн хангасан. Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшинг илүү дээшлүүлэх
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2	1		7.1 Хэсэгчлэн хангасан. Дотоод чанарын үнэлгээний бүтэц бий болсон. Хяналтын механизмыг сайжруулах
Дүгнэлт		Бүрэн хангасан			

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

- Хөтөлбөрийн агуулга, бүтцийг мэргэжлийн чиглэлийг нарийвчлан тогтоохтой уялдуулан байнга сайжруулалт хийж байх;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг шат дараатай ахиулах;
- Дадлагын түшиц бааз суурьтай болох;
- Оюутны мэргэжлийн хандлагыг дээшлүүлэх, төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах;
- Ном, сурах бичгийн хүртээмжийг улам нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хангах;
- Ажил олгогчдын эрэлт, хүсэлтийг хөтөлбөрт тусгах талаар байнгын судалгаа хийж, боломжит өөрчлөлтийг цаг алдалгүй хийж байх;
- Олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэх бэлтгэл ажлыг урт хугацааны төлөвлөгөөтэй хийх;

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Бизнесийн сургуулийн “Эдийн засаг” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлагад нийцэж байгаа тул шалгуурыг “БҮРЭН ХАНГАСАН ” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг

Ц.Даваадорж

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

Х.Цэвэлмаа

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

Л.Отгонжаргал

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Д.Батсуурь	Ахлах багш	Магистр		
2	Л.Бямбасүрэн	Ахлах багш	Магистр		
3	Ш.Мөнгөнсүх	Ахлах багш	Магистр		
4	Д.Цэрэнханд	Ахлах багш	Магистр		
5	Т.Тогтохбуян	Ахлах багш	Магистр		
6	Д.Энхболд	багш	Магистр		
7	Т.Энхсайхан	багш	Магистр		
8	А.Энхсүрэн	Багш	Магистр		
9	С.Сүхболд	багш	Магистр		
10	У.Хишигдалай	Ахлах багш	Магистр		
11	П.Цэрэндаваа	багш	Магистр		
12	Б.Хишигтогтох	багш	Магистр		
13	Н.Ариунжаргал	Дадлагажигч багш	Магистр		
14	Б.Ариунгэрэл	Дадлагажигч багш	Магистр		
15	Э.Оюун-Эрдэнэ	Дадлагажигч багш	Магистр		
16	Ө.Түвшинжаргал	Дадлагажигч багш	Магистр		
17	Э.Мөнх-Уянга	Дадлагажигч багш	Магистр		

II. Оюутны нэрс

Уулзалтанд оролцох оюутны нэрс /2019.05.22/

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Гарын үсэг
1	С.Чинхүсэл	1	Голч өндөртэй, УБ хотынх	С. Чинхүсэл
2	Болорчимэг	1	УБ хотынх	Б. Болорчимэг
3	Номин-Эрдэнэ	1	Голч өндөртэй, орон нутгийнх	Номин-Эрдэнэ
4	Б.Одгэрэл	1	Дотуур байранд амьдардаг.	Одгэрэл
5	Энгүүн	1	Голч өндөртэй, УБ хотынх	Т. Энгүүн
6	Номин	2	Дотуур байранд амьдардаг.	Б. Номин
7	Анужин	2	Голч өндөртэй, УБ хотынх	Н. Анужин
8	Оргилбаатар	2	Тааруу сурдаг, УБ хотынх	
9	Ёндон	2	Орон нутгийнх	Т. Ёндон
10	Отгонбаяр	2	Дундаж сурлагатай, УБ хотынх	С. Отгонбаяр
11	Б.Баасанхүү	3	Төрийн сангийн тэтгэлгээр сурдаг	Б. Баасанхүү
12	Б.Ариунбат	3	Төрийн сангийн тэтгэлгээр сурдаг	Б. Ариунбат
13	Б.Нэмэхдалай	3	Өндөр голчтой	Б. Нэмэхдалай
14	А.Нармандах	3	Бага голчтой	А. Нармандах
15	Б. Амгалан	3	Дундаж голчтой	Б. Амгалан
16	Г.Амгалан	4	Онц сурдаг, УБ хотынх	Г. Амгалан
17	Ч.Бат-Эрдэнэ	4	Онц сурдаг, орон нутгийнх	Ч. Бат
18	Ёлка	4	Тааруу сурдаг, орон нутгийнх	Ёлка
19	Т.Мөнхчимэг	4	Дотуур байранд амьдарч байсан, орон нутгийнх	Т. Мөнхчимэг
20	Э.Одгэрэл	4	Онц сурдаг, орон нутгийнх, нийгмийн идэвхтэн	Э. Одгэрэл

III. Ажил олгогчдын нэрс









Уулзалтанд оролцох ажил олгогчдын нэрс

2019.05.23

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1	Дуламжав	"Ecorack Mongol" ХХК	98111224	<i>W. Duламжав</i>
2	Мөнхмарал	"BRB" ХХК, Хүний нөөцийн менежер	97016767	<i>Мөнхмарал</i>
3	Минжбадгар	"Голомт банк" Хүний нөөцийн менежер	91110650	<i>Минжбадгар</i>
4	Гансүвд	Люминер ХХК Менежер	89002286	<i>Г. Гансүвд</i>
5	Болорцэцэг	"ХХБ" ахлах менежер	88081396	
6	Золбадрах	"Их Минж" ХХК, захирал	99997346	<i>З. Золбадрах</i>
7	Энхтайван	Монголын Актуарчдын Нэгдсэн Институт	99050943	<i>Э. Энхтайван</i>
8	Гомбожав	"Steolf Global Investment" LLC, Chief strategy officer	99998740	<i>Г. Гомбожав</i>
9	Хулан	MCS груп, хүний нөөцийн менежер	88104008	
10	Баасансүрэн	"Суурь Төр" ХХК, захиргаа хүний нөөцийн ажилтан	99140944	<i>Б. Баасансүрэн</i>
11	Амартүвшин	"Сүлжээ" ТӨК, Эдийн засгийн хэлтсийн дарга	99085841	
12	Хишигтулга	"Номин" ХХК, албаны дарга	88100368	
13	Болор-Эрдэнэ	Lendmn, хүний нөөцийн менежер	99919241	

14. Б.Түвшээ - Хаан Банк - 99075514
 15. С.Ариа - Хаан Банк - 99901641
 16. О.Ядамсүрэн - ХААН Банк - 99098131
 17. М.Золбоорах - Их Минж ХХК - 99997346

IV. Төгсөгчдийн нэрс

Уулзалтанд оролцох төгсөгчдийн нэрс			2019.05.23		
№	Овог нэрс	Төгссөн он	Баигууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1	Оюундарь	2014	Үндэсний Статистикийн Хороо	80115855	
2	Б.Оюумаа	2015	Ард банк, ахлах теллер	86280459	
3	З.Золжаргал	2015	хувиараа	99150714	
4	С.Хишигдэлгэр	2015	ХХБ	99974014	
5	Гүн	2015	Хаан банк	99025891	
6	Дөлгөөн	2016	Юнител	89111002	
7	Энхтуул	2016	Худалдаа хөгжлийн банк	88178394	
8	Жүгдэрнамжил	2016	Хувиараа	98113025	
9	О.Ананд	2017	Голомт банк	95090770	
10	Бат-Өлзийт	2017	хувиараа	95012323	
11	Лхагвасүрэн	2016	"Сүлжээ" ТӨК, мэргэжилтэн	99779154	
12	Өсөхбаяр	2018	Голомт банк	88103423	
13	Төмөр	2018	ХХБ	99218448	
14	Отгонзаяа	2018	Голомт банк	99011397	
15	Соёл-Эрдэнэ	2014	Зам Тээврийн Яам	99064020	
16	Батцэцэг	2018	Эдийн засагч	86052335	

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/